



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 04 сарын 03 өдөр

Дугаар А/20

Улаанбаатар хот

### Ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/242 дугаар захирамж, Газрын дүрмийн 4.1.4, 4.1.8, 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалт зохион байгуулах ажлын төлөвлөгөөг дүүрэг бүрт хариуцан хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг батлагдсан удирдамж, хуваарийн дагуу холбогдох нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, явц үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг Ажлын хэсгүүдэд үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э. Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

  
С.ТӨМӨРДУЛАМ

1150500105

Газрын даргын 2023 оны 04 дугаар сарын 03-ны өдрийн Аво дугаар тушаалын наядуулар хавсралт



## ДҮҮРГҮҮДЭД АЖИЛЛАХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

| № | Дүүрэг          | Ахлагч   | Гишүүд, нарийн бичиг  |
|---|-----------------|--|---|
| 1 | Баянгол         | Г.Уртнасан<br>(Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)   | Гишүүд:<br>- Ч.Ганхуяг (Газрын тос, хийн хяналтын улсын байцаагч)<br>Нарийн бичиг<br>- Ч.Нанжид /Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн/  |
| 2 | Баянзүрх        | Б.Тамир<br>(Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Эрчим хүчний хяналтын улсын байцаагч) | Гишүүд:<br>- Н.Ёндонсамбуу (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)<br>- Т.Мөнхжаргал (Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)<br>- О.Жинэр (Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтан)<br>Нарийн бичиг<br>- П.Мөнхзаяа (Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн) |
| 3 | Чингэлтэй       | Т.Мөнхболд<br>(Газрын тос хийн хяналтын улсын байцаагч)  | Гишүүд:<br>- Ө.Асылбек (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)<br>Нарийн бичиг<br>- Б.Батболд (Захиргаа, санхүүгийн хэлтсийн Цахим хөгжүүлэлт хариуцсан ажилтан)   |
| 4 | Сүхбаатар       | Б.Найрамдал<br>(Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн дарга, улсын ахлах байцаагч)                         | Гишүүд:<br>- Б.Шинэжаргал (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)<br>- И.Ариунболд (Автозамын хяналтын улсын байцаагч)<br>Нарийн бичиг:<br>- Ц.Номин (Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн)   |
| 5 | Сонгино хайрхан | З.Ганбат<br>/Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн ахлах мэргэжилтэн,                         | Гишүүд:<br>- Ц.Алтансүх (Барилгын техникийн хяналтын улсын ахлах байцаагч)<br>- У.Энхтөр (Тээврийн хяналтын улсын байцаагч)<br>- Н.Жигжиддорж (Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн)   |



|   |                            |  |  |
|---|----------------------------|--|--|
|   |                            | улсын ахлах байцаагч   | Нарийн бичиг:<br>Д.Энхтуяа (Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн)  |
| 6 | Хан-Уул                    | Д.Өлзийсайхан (Байгаль орчны стандартын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч)                        | Гишүүд<br>- Ж.Жүгдэрмаа (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)<br>- З.Очирпүрэв (Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)<br>- Л.Хүрэлтушаа (Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн)<br>Нарийн бичиг:<br>- Х.Байгал (Худалдаа, үйлчилгээний стандартын хэлтсийн мэргэжилтэн) |
| 7 | Багахангай Багануур Налайх | Д.Дуламрагчаа (Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Авто замын хяналтын улсын ахлах байцаагч) | Гишүүд:<br>- Ц.Тогтохбуян (Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)<br>- Т.Батсүх (Барилгын техникийн хяналтын улсын байцаагч)<br>Нарийн бичиг:<br>- Б.Хулан (Байгаль орчны стандартын хэлтсийн мэргэжилтэн)   |
| 8 | Ерөнхий нарийн бичиг       | Д.Өлзийсайхан (Байгаль орчны стандартын хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэгч)                        |  |

Газрын даргын 2023 оны 04 дугаар  
сарын 03-ны өдрийн 9/20 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



## УДИРДАМЖ

2023 оны 04 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

### Дүүргүүдэд хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах тухай

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1 Нийслэлийн Засаг даргын 2023 оны "Хууль, норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах талаар авах зарим арга хэмжээний тухай" А/242 дугаар захирамжийн хэрэгжилтийг хангуулахад тус газрын хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй, бүрэн хангалттай хэрэгжүүлж, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу дүүргүүдэд байгуулагдах ажлын хэсгүүдэд зөвлөн тусалж, хамтран ажиллах замаар хууль тогтоомж, стандарт, нормыг хэрэгжилтийг сайжруулах нь энэхүү удирдамжийн зорилго юм.

1.2 Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/174 дүгээр захирамжаар батлагдсан газрын дүрмийн 4.1, 4.2-д заасан үндсэн чиг үүргийн хэрэгжилтэд холбогдох нэгж, албан хаагчдын оролцоог жигд хангуулж, үүрэг хариуцлагыг дээшлүүлнэ.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт.

2.1 Дүүргүүдэд хуваарилагдсан ажлын хэсэг дараах үүрэгтэй ажиллана.

2.1.1 Ажлын хэсгийн ахлагч нь хариуцсан дүүргийн хэмжээнд дээрх захирамж, төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, ажлын хэсгийн гишүүдийг удирдлага, арга зүй, уялдаа холбоогоор хангана.

2.1.2 Ажлын хэсгийн гишүүд нь байгууллагын чиг үүрэгтэй холбоотой асуудлаар дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах зөвлөн туслах, сургалт, арга зүйгээр хангах, хяналт шалгалт хийх ажилд оролцох ба дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулагдах ажлын хэсгийн гишүүнээр томилогдож ажиллана.

2.1.3 Ажлын хэсэгт ажиллах улсын байцаагч нар нь өөрийн хариуцсан чиг үүрэгт хамааралтай асуудлаар илэрсэн зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдлийг таслан зогсоож, шаардлагатай тохиолдолд холбогдох аж ахуйн нэгж, иргэнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож арга хэмжээ авна.

2.1.4 Улсын байцаагч нар өөрийн чиг үүрэгт хамааралгүй боловч тодорхой зөрчлийн шинжтэй нөхцөл байдлыг баримтжуулан, бүртгэж холбогдох улсын байцаагчид мэдэгдэнэ.

2.1.5 Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь тус газрын хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээний мэдээлэл, биелэлт, үр дүнг нэгтгэн ажлын хэсгийн дарга болон газрын удирдлагыг тогтмол мэдээллээр хангана.

2.1.6 Ерөнхий нарийн бичгийн дарга нь нийслэлийн хэмжээнд төлөвлөгөөний биелэлт, үр дүн, тайлан, мэдээг нэгтгэн Улаанбаатар Ерөнхий менежер болон газрын удирдлагад 14 хоног бүрт тайлагнана.



2.2 Төлөвлөгөөнд тус газрын хариуцсан арга хэмжээг хэрэгжүүлэх талаар тухайн дүүрэг, хороодын албан хаагчидтай дараах байдлаар хамтран ажиллана.

2.2.1 Мэдээлэл солилцох:

- Хууль тогтоомж, стандарт, норм дүрэм
- Судалгааны үр дүн, мэдээ, баримт

2.2.2 Төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх:

- Дүүргийн ажлын хэсгийн нарийвчилсан төлөвлөгөөг сар бүр гаргах, арга хэмжээ нэг бүрээр хариуцах эзэн, тайлагнах хугацаа зэрэг үзүүлэлтийг тусгуулж, байгууллагын чиг үүрэгт хамааралтай ажилд идэвхитэй оролцох;
- Дүүрэг, хороодын албан хаагчдад зөвлөн тусалж арга зүйгээр хангах;
- Хамтарсан судалгаа хийх;
- Хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах

Гурав. Биелэлт, үр дүнг тайлагнах, мэдээлэх

3.1 Ажлын хэсэг бүр хариуцсан дүүргийн хэмжээнд төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн талаарх тайлан, мэдээг дараах байдлаар бэлтгэж

3.1.1 Тус газрын болон тухайн дүүргийн удирдлагыг цахим сүлжээний хэрэгслээр дамжуулан тогтмол мэдээллээр хангана;

3.1.2 дүүргийн Засаг даргын Тамгын газраас Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн шуурхай хуралдаанд төлөвлөгөөний хэрэгжилтийг 14 хоног бүр танилцуулах тул дүүрэг дэх ажлын хэсэгт гүйцэтгэсэн ажлын дүн, мэдээг тухай бүр өгч ажиллах;

3.1.3 Стандарт, норм зөрчигдсөн, орчны аюулгүй байдал алдагдсан байршлуудын мэдээллийг бүртгэж мэдээллийн сан үүсгэх, фото зургаар баримтжуулна; (*өмнө, хойно гэсэн байдлаар*)

3.1.4 Төлөвлөгөөнд туссан арга хэмжээний явцыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилан мэдээлнэ.

3.2 Төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн хурал, Нийслэлийн Засаг даргын шуурхай хуралдаанд танилцуулах бэлтгэл хангуулж оролцоно.

3.3 Дүүргүүдэд ажиллахдаа гадуур ажлын дэвтэр, ажлын өдөр тутмын тэмдэглэл /Google sheet/-ийг газрын дотоод дүрэм, журамд заасны дагуу тогтмол хөтөлнө.

Дөрөв. Хяналт, хариуцлага

Энэхүү тушаал, удирдамжийн дагуу хариуцсан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлээгүй албан тушаалтан, албан хаагчдад Төрийн албаны тухай хууль, байгууллагын дотоод дүрэм, журмын дагуу хариуцлага тооцож ажиллана.

\_оОо\_